

Жишээ, 1-р хэсэг

Луис номлолоосоо эргэж ирээд, бараг хоёр жил болж байна. Тэр ирээдүйн гэр бүлээ хангаж чадах эсэхэд санаа зовдог тул сургуульдаа суралцахын хажуугаар хагас цагийн ажил хийхээр шийджээ. Тэр цаг зав багатай боловч долоо хоног бүр институтэд явах дуртай төдийгүй үүнийг эн тэргүүнд тавьдаг. Луис ихэвчлэн социал медиа ашигладаг ба хичээлийн өмнө юм уу автобусаар зорчиж байхдаа тоглоом тоглодог. Тэр эргэж ирснээсээ хойш тийм ч олон охинтой танилцаагүй. Тэр сургуулиа төгссөнийхөө дараа л гэрлэхээр нухацтай хичээсэн нь дээр гэж гэр бүлийнхэндээ хэлдэг. Хэрэв удахгүй гэрлэх ёстой бол болох ёстой зүйл болдгоороо болно гэж тэр боддог.

Эмма Луисын явдаг институтэд явдаг боловч хэзээ ч түүнтэй уулзаж байгаагүй. Тэр ихэвчлэн найз нөхөдтэйгөө хамт сууж, өөр хүнтэй бараг л ярьдаггүй. Тэр ерөнхийдөө залуустай уулзаж, болзохоос залхсан. Тэр өөр нэг харилцаа эхлүүлбэл энэ нь бусад харилцааны л адил дуусна гэж санаа зовдог. Тэр сэтгэл санаагаар туйлдсан ба өөр харилцаанд орох хангалттай эрч хүчгүй болсон. Тэр жилийн өмнө сургуулиа төгссөн, одоо бүтэн цагаар ажилладаг. Тэр жинхэнэ хайртайгаа хэзээ ч учрахгүй эсвэл ариун сүмд гэрлэхгүй гэдэгтээ санаа зовнидог мөн Сүмээс гадуур хэн нэгэнтэй болзох хэрэгтэй эсэх талаар боддог.

Энэхүү хувилбарыг хамтдаа уншаад, дараах асуултуудыг ярилц.

- Та Луис, Эмма хоёрын санаа зовнилын талаар юу бодож байна вэ?
- Бэлтгэх материалын 1-р хэсгээс сурсан зүйлээс харахад, Луист ямар зөвлөгөө тус болох вэ? Эммад ямар зөвлөгөө тус болох вэ?
- Хэрэв та бүлгийн ярилцлагадаа дараах судрын хэсгүүдийн талаар ярилцаагүй бол хамтдаа уншаад, эдгээр нь хэрхэн Луис, Эмма хоёртой холбогдож болохыг хэлэлц. Үүнд: Сургаалт үгс 3:5–6; 2 Нифай 22:2; Сургаал ба Гэрээ 58:26–28. Мөнхийн ханиа олохоор хичээхдээ та Их Эзэнд итгэх итгэлээ хөгжүүлж байгаа юу эсвэл хэрхэн хөгжүүлж болох вэ?